



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 4/872

Улаанбаатар хот

Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг,
улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа,
үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдийг сонгон
шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Нийслэлийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх “Маршалын гүүрний цэцэрлэгт хүрээлэн”-ийн авто зогсоол, “Дугуй цагаан” амралт зугаалгын бүсэд явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг, улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа, үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Цэрэн
Засаг даргын орлогч

Гишүүд:

Л.Саруултуяа
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Ч.Байгаль
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Т.Дамбийнам
Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын дарга

Д.Гомбосүрэнжав
Хан-Уул дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга

Г.Сүрэнтамжид
Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн дарга

Э.Цогбадрал
Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны албаны дарга (Зөвшүүлцсөнөөр)

Ц.Барсхүү
Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн
Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, Хошууч

726010778

Ө.Цоггэрэл

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эрүүл
мэндийн хяналтын хэлтсийн Орчны эрүүл ахуйн
хяналтын улсын байцаагч (Зөвшилцсөнөөр)

Б.Хонгор

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Хяналтын хэлтсийн Хүнсний чанар, стандартын
хяналтын улсын ахлах байцаагч (Зөвшилцсөнөөр)

С.Ариунтуяа

Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны Засаг дарга

Б.Мөнхболд

Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны Засаг дарга

Нарийн бичиг:


Г.Тэргэл

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Хоол
үйлдвэрлэл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

2.Худалдаа үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын
удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулж,
дүнг нийтэд мэдээллэж ажиллахыг ажлын хэсэг (Б.Цэрэн)-т уурэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж. АЛДАРЖАВХЛАН

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2024 оны 05 ынварын сарын
13-ны өдрийн 04/05/2024
захирамжийн хавсралт

ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ТҮРГЭН ХООЛНЫ ЦЭГ, УЛИРЛЫН ЧАНАРТАЙ
ТҮРСҮҮДРЭВЧТЭЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл ахуйн тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам батлах тухай" 34 дүгээр тоогоол, Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг, Техникийн ерөнхий шаардлага MNS 6192 : 2010 стандарт

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нь Хан-Уул дүүрэгт татвар төлөгч жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг Хан-Уул дүүргийн иргэн, хуулийн этгээд байна.

Гурав. Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа

1.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг дүүргийн <https://khanuu.mn/> цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээллэнэ.

1.2. Сонгон шалгаруулалтын хүсэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 08:00 цагаас 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст танилцуулга хэлбэрээр цаасаар хүлээн авна.

1.3. Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн хүсэлтийг тавигдах шаардлага, бүрдүүлсэн баримт бичгийн бүрдлийн дагуу магадлан шалгаж, дүнг нийтэд мэдээллэнэ.

1.4. Маршалын гүүрний цэцэрлэгт хүрээлэнгийн авто зогсоолд нийт 8 иргэн, хуулийн этгээд;

1.5. Дугуй цагаан амралт зугаалгын бүсэд 10 хүртэлх иргэн, хуулийн этгээд сонгон шалгаруулна.

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага

4.1. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг нь стандартын шаардлагыг хангасан байгууламжтай, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, өнгө үзэмжтэй, үйл ажиллагааны онцлогт тохирсон чимэглэлтэй байна.

4.1.2. Гадна талбайн борлуулалтын хэсэг нь автозам, явган зорчигчдын хөдөлгөөнд саад учруулахгүй, хур тунадаснаас хамгаалагдсан саравчтай байна.

4.1.3. Тогооч нь мэргэжлийн үнэмлэхтэй, ажиллагсад эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан, хувийн ариун цэврийн шаардлага хангасан, ил харагдахуйц шархгүй, нэг удаагийн шулсэвч, амны хаалт, бээлийн зэргийг хэрэглэнэ.

4.1.4. Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг горимын дагуу хадгалах, технологийн дагуу боловсруулах, худалдах, үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж, хоол, хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, дагалдах баталгаажилтын баримт бичгийг бүрдүүлсэн байна.

4.1.5. Хэрэглэсэн тос, бохир усыг зайлцуулах хаалтаар тусгаарласан зориулалтын сав бүхий угаалтуур эсвэл шууд гадагшaa гарсан хоолойгоор бохирыг соруулж авах тоноглол савтай байна.

4.1.6. Орчныхоо цэвэрлэгээг бүрэн хариуцаж, явуулын хоолны цэгийн гадна талд хогийн сав байрлуулан, хатуу, шингэн хог хаягдлыг нэгдсэн цэгт хаядаг байна.

4.1.7. Хүнсний зориулалтын нэг удаагийн аяга таваг, халбага, сэрээ, цаасан уут ашиглан үйлчилгээ үзүүлнэ.

4.1.8. Галын аюулгүй байдлыг хангаж цахилгааны ашиглалт, угсралтыг стандартын дагуу хийлгэж галын хор байрлуулах.

- Хийн баллоны ашиглалт, угсралтыг стандартын дагуу хийлгэж хий мэдрэгч дохиолол, хийн тоног төхөөрөмж ашиглах сургалтад хамрагдаж сертификат авсан байх.

4.1.9. Нийтийн аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хамгаалах хүрээнд дүрс бичлэгийн хяналтын камер суурилуулсан байна.

4.1.10. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ авах иргэдийн тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр байршуулах боломжийг бүрдүүлж ажиллана.

4.1.11. Татварын системд холбогдсон, кассын төхөөрөмжөөр төлбөр тооцоог хийж, үйлчлүүлэгчдэд төлбөрийн баримт олгодог байна.

4.2. Улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1. Байгууламж нь өнгө үзэмжтэй, өөрийн өнгө төрхийг илэрхийлсэн чимэглэлтэй байна.

4.2.2. Ажиллагсад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан, зориулалтын хувцас хэрэгсэлтэй байна.

4.2.3. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан, түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний бичигтэй байна.

4.2.4. Орчны эрүүл ахуйн шаардлагыг хангасан, хог хаягдлыг түр хадгалах зориулалтын хогийн савтай байна.

4.2.5. Галын аюулгүй байдлыг ханган ажиллана.

4.2.6. Татварын системд холбогдсон, кассын төхөөрөмжөөр төлбөр тооцоог хийж, үйлчлүүлэгчдэд төлбөрийн баримт олгодог байна.

Тав. Сонгон шалгаруулалтад оролцогчын бүрдүүлэх баримт бичиг

5.1. Сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах баримт бичгийг хүлээн авна:

5.1.1. Албан хүсэлт, өргөдөл;

5.1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагaa;

5.1.3. Өөрөө явагч тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ (явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг эрхлэгч);

5.1.4. Байгууламжийн гадна болон дотор тохижилтын талаарх зурган мэдээлэл, танилцуулга;

5.1.5. Ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний дэвтэр, мэргэжлийн үнэмлэх, хувцас хэрэгсэл, хэрэглэж буй нэг удаагийн сав хэрэгслийн танилцуулга;

5.1.6. Худалдан борлуулах бүтээгдэхүүний шинжилгээний бичиг, зурган танилцуулга;

5.1.7. Галын аюулгүй байдлыг ханган ажиллах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал, Хог хаягдал түр хадгалах зориулалтын хогийн савтай, орчны цэвэрлэгээ үйлчилгээ, багаж хэрэгсэл, ажлын талбай, гадаргуу зэрэгт халдвартгүйжүүлэлт хэрхэн хийдэг талаарх танилцуулга;

5.1.8. Дүрс бичлэгийн хяналтын камер суурилуулсан талаар мэдээлэл (явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг эрхлэгч);

5.1.9. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, үйлчилгээ авах иргэдийн тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд саад учруулахгүйгээр байршуулах боломжийг бүрдүүлж ажиллах талаар оновчтой хэлбэрээр санал танилцуулга ирүүлэх;

5.1.10. Татварын системд холбогдсон, кассын төхөөрөмжөөр төлбөр тооцоог хийж, үйлчилгүүлэгчдэд баримт олгодог талаар танилцуулга;

Зургаа. Гэрээ байгуулах

6.1. Сонгон шалгаруулалтад шалгарсан иргэн, хуулийн этгээдтэй дүүргийн менежер, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа гурвалсан гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг нарийвчлан тусгана:

6.1.1. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг, улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн ажиллах цагийн хязгаар

6.1.2. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг, улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа үйлчилгээнд тавигдах тусгай шаардлага

6.1.3. Орчны эрүүл ахуй, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдвартгүйтгэл

6.1.4. Хүнсний аюулгүй байдал, галын аюулгүй байдал, нийтийн аюулгүй байдал

6.1.5. Амрагч, үйлчилгүүлэгчдийн тээврийн хэрэгслийг чөлөөтэй байршуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах

6.1.6. Гомдол саналыг хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага хүлээх

Долоо. Бусад зүйл

7.1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд аливаа байгууллага, албан тушаалтан, эрх бүхий этгээдийн зүгээс нелөө үзүүлэхийг хориглоно.

7.2. Сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

---оо---